



ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

ТАБ-ын Дарга, тэргүүлэх аудитор

Л.Жаргалсайхан

И-мэйл: jargalsaihan_tuv@yahoo.com

Утас: 70272582

Факс: 01-272-22582

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

ХавсАралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудитын менежер:

О.Амаржаргал

И-мэйл: amaraa_tuv@yahoo.com

Утас: 70273465

Ахлах аудитор Т.Майцэцэг

Утас: 70273204 99018619

И-мэйл: maits2009@yahoo.com

Аймгийн аудитын газрын хаяг:

Төв аймаг Зуунмод сум 1-р баг

Төрийн байгууллагуудын ордон

Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.3, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Эрдэнэ сумын ЗДТГазрын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд ТӨВ-2017/155 /СТА-ТШЗ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Төв аймгийн Эрдэнэ сумын ЗДТГазрын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төв аймгийн Эрдэнэ сумын ЗДТГазрын төсвийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 25-наас 2017 оны 03 дүгээр сарын 25-ныг хүртэл хийхээр төлөвлөн ТАБ-ын аудитын багийн гишүүн аудитор Т.Майцэцэг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Төв аймгийн Эрдэнэ сумын ЗДТГазрын төсвийн 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 01 дугаар сарын 26-нд ТАБ-т ирүүлсэн байна.

Төрийн аудитын байгууллага аудитыг 2017 оны 03 дүгээр сарын 09-наас 2017 оны 03 дүгээр сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 03 дугаар сарын 16-нд Төв аймгийн Эрдэнэ сумын ЗДТГазрын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн захирагч нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дүгээр зүйлийн 1-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын ажлын алба нь Тамгын газар байх бөгөөд дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ.” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тус хуулийн 33 дүгээр зүйлд тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 6.2.-т “Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн орлогын нэр төрөл, зарлагын ангилал, санхүүжилтийн зориулалт болон төсөв зохиох, батлах, гүйцэтгэлийг зохион байгуулах, тайлагнах үйл ажиллагааг төсвийн болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.38-д “төсвийн шууд захирагч “ гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг” 16 дугаар зүйлийн 16.4.18-д төсвийн бусад байгууллагын дарга (захирал, эрхлэгч) тухайн байгууллагын төсвийн төсвийн шууд захирагч байна гэж заасны дагуу Төв аймгийн Эрдэнэ сумын ЗДТГазрын дарга Төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийг сумын ИТХурлаас баталж аймгийн Төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нийцлийн аудитын стандарт 4200, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Төв аймгийн Эрдэнэ сумын ЗДТГазрын төсвийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс Төв аймгийн Эрдэнэ сумын ЗДТГазрын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын батлагдсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийн шатанд аудитын хяналтын болон нарийвчилсан 8 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ТШЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт шинээр гарсан хуулийн заалт, Сангийн сайдын журам зааварт орсон өөрчлөлтийг бүрэн тусгаж боловсруулсан. Сангийн яамнаас зөвшөөрөл бүхийн Санхүүгийн тооцоолох ХХК-ний бүртгэлийн асcolous програм ашигладаг байна.

Төсвийн шууд захирагчид ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Төв аймгийн Эрдэнэ сумын ЗДТГазрын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Тус байгууллага нь дотоод хяналтын ажлын төлөвлөгөө тайлан ирүүлээгүй, ажиллаагүй. Иймд хөрөнгийн тооллого, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт зэрэг санхүүгийн механизмыг бүхэлд нь хянадаггүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн программаар боловсруулж байна. Эдгээр журам нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Төв аймгийн Эрдэнэ сумын ЗДТГазрын Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

Төв аймгийн Эрдэнэ сумын ЗДТГазрын 2016 оны зарцуулах эрхийг аймаг, сумын ИТХ-аас 405936.7 мянган төгрөгийн санхүүжилт, эх үүсвэр авахаар баталж, сангийн яамнаас баталгаажуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар Эрдэнэ сумын ЗДТГазар нь 2016 онд батлагдсан төлөвлөгөөгөөр 405936.7 мянган төгрөг зарцуулахаас, гүйцэтгэлээр 412095.5 мянган төгрөгийг зарцуулсан ба төсвийн зарцуулаагүй татан төвлөрүүлсэн үлдэгдэл 546.0 мянган төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд төвлөрүүлэх шилжүүлгээр тайлагнасан байна.

ЗДТГазрын нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар 30054.6 мянган төгрөгийг тайлагнасан байна

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу 2015 оноос “shilendans.gov.mn” цахим сайтад зохих мэдээллийг оруулсан. ҮАГ-аас нэгдсэн удирдамжаар шилэн дансны хэрэгжилтэнд 2016 оны 10-р сарын байдлаар гүйцэтгэлийн аудит хийгдсэн. 2016 онд тус байгууллага нь шилэн дансанд 85 мэдээллийг хугацаанд нь оруулж, 63 мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд батлагдсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийн шатанд мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал, орлого, зардал зэрэг дансдад 8 горим сорил хэрэгжүүлсэн.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Эдгээр эрсдэлүүд нь төсвийг хэмнэлтгүй зарцуулсан, төсвийг үр ашиггүй зарцуулсан, төсвийн зориулалтыг зөрчсөн, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сулруулж цаашид хөрөнгийг үрэгдүүлэх, чанар байдлыг алдагдуулах, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг бууруулсан, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй зөрчдөг зэрэг муу үр дагаварт хүрч болзошгүй байна

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Төв аймгийн Эрдэнэ сумын ЗДТГазрын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, эхний 9 сарын завсарын аудитад тулгуурлан аудитын явцад цаг хугацааны хязгаардагдмал байдлаас шалтгаалан цалингийн зардал, хөрөнгийн тооллогын бүртгэл тооцоо бодолтыг тулган шалгаагүй, санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний дүнтэй ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Аудитад ирүүлсэн анхны санхүүгийн тайланд батлагдсан төсвийг 371294.5 мянган төгрөгөөр буюу 34642.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан. Төсвийн тухай хуулийн 6.5.3.төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд олон нийт хяналт тавих боломжоор хангах; 7.4.Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрээр, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг улирал, хагас жил, бүтэн жилээр бэлтгэж, тайлагнана гэж заасантай нийцэхгүй байна. анхүүгийн тайлангийн батламж мэдэгдэл иж бүрэн байх, үнэн зөв байдал, бодит байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй

Шийдвэрлэсэн: Алдааг хүлээн зөвшөөрч аудитын явцад залруулсан.

2. Нөөц дансанд оны эхэнд 7123.3 мянган төгрөг орлого 20130.0 мянган төгрөг тайлагнасан Сангийн сайдын 2005 оны 276-р тушаалаар батлагдсан дансны нэгдсэн жагсаалтын зааварт "Нөөцийн бараа" гэж байгалийн аюулаас хамгаалах, улс орны батлах хамгаалах болон дотоодын зах зээлийн улиралын шинж чанартай хэрэгцээг зохицуулах зорилгоор стратегийн ач холбогдолтой бүтээгдэхүүний нөөцийг энэ дансанд бүртгэнэ гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Алдааг хүлээн зөвшөөрч аудитын явцад залруулсан.

3. СХСангийн зээлийн олголт 22600.0 мянган төгрөгийг Мөнгөн гүйлгээний тайланд тайлагнаагүй байна. Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.5.3.төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд олон нийт хяналт тавих боломжоор хангах; УСНББОУСтандарт 2 Мөнгөн гүйлгээний тайлан 18-д Мөнгөн гүйлгээний тайланд тайлант үеийн үндсэн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын болон санхүүгийн үйл ажиллагаа тус бүрээр ангилсан мөнгөн гүйлгээг тайлагнах ёстой гэж заасантай нийцэхгүй байна.Санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Алдааг хүлээн зөвшөөрч аудитын явцад залруулсан.

4. Санхүү үр дүнгийн Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 94236.3 мянган төгрөг нь ҮХ дансанд тусламж хандиваар 30906.3 мянган төгрөг, Бараа материал дансанд 33330.0 мянган төгрөг 64236.3 мянган төгрөг Зөрүү 30000.0 мянган төгрөг , Төсвийн хөрөнгөөр 10653.0 мянган төгрөгийг төсвийн хөрөнгөөр бүртгэсэн байна. НББ-ийн

тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.3.холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;

Шийдвэрлэсэн: Алдааг хүлээн зөвшөөрч аудитын явцад залруулсан.

5. Авлагын оны эхний үлдэгдэл 2179.0 мянган төгрөгийн барагдуулалтыг шалгахад 100.0 мянган төгрөгийг барагдуулсан. Барагдуулаагүй авлага 3-4 жилийн насжилттай, авлагын журналас түүвэрлэн шалгахад Б.Чанцалдуламаас 1540.0 мянган төгрөг ажилчдын хувцасны авлага, Төв аймгийн 90 жилийн ойн билетний үнэний дутуу 135.0 мянган төгрөг, Билгүүн хонгор ХХК-д нүүрсний үнэ илүү шилжүүлсэн 404.9 мянган төгрөг гэсэн тайлбартай нийт 2079.9 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй зөрчил илэрлээ. Төсвийн тухай хуулийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх: НББ-ийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Авлагыг барагдуулахаар төлбөрийн акт тогтоов.

6. Түлш халаалтын зардлаас дулааны улиралд буюу 5-р сард 32 м3 буюу 960.0 мянган төгрөгийн, 7-р сард 8 м3 буюу 240.0 мянган төгрөгийн нийт 1200.0 мянган төгрөгийн түлээний мод бэлтгэж, төсвийг аривлан хэмнэлтгүй зарцуулсан. Түлээний модыг зарлагадахдаа тухайн өдөрт нь бэлтгэн нийлүүлэгч иргэн бичсэн шаардах хуудсыг дарга, ня-бо зөвшөөрч, нярав олгосон, бэлтгэн нийлүүлэгч өөрөө хүлээн авсан гарын үсэг зурсан баримтаар зарлагын гүйлгээ хийсэн зөрчил илэрлээ Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; НББ-ийн тухай хуулийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно. 13.6.Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Зардлыг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Бусад үндсэн хөрөнгө дансанд 384.7 мянган төгрөгийн гарын авлага, ном эмхэтгэл сэтгүүл үлдэгдэлтэй байна. Нярав эд хариуцагч нь үндсэн хөрөнгийн данснаас 5364.7 мянган төгрөгийн актлаж хассан материалын тайланг хийгээгүй, ня-бо санхүүгийн программд шийдвэрийн дагуу хассан. Тооллогын комисс тооллогын бүртгэлд чанар байдал бичээгүй, дүнг дүгнээгүй, ня-бо тулган тооцоо бодоогүй. НББ-ийн тухай хуулийн 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах; ТБОНӨТХуулийн 72.4.4-д комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх, заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

2. Байгаль хамгаалах зардлаас Ойн бүргэд ХХК-нд ойн цэвэрлэгээний зардалд 10425.0 мянган төгрөг, нийтийг хамарсан хог цэвэрлэгээнд болон хогийн цэгийн тохижилтонд 4500.0 мянган төгрөг, нохой устгалд 684.7 мянган төгрөг, эргүүл, шатахууны зардалд 2660.2 мянган төгрөг нийт 18269.9 мянган төгрөг зарцуулсан. Сумын ИТХ-ын хурлаар байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын задаргааг батлагдаагүй тул зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг хянах боломжгүй байв. Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Сумын ИТХ-аар байгаль хамгаалах арга хэмжээний зардлын задаргааг батлуулж зардлыг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулах зөвлөмж өгөв.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Материаллаг бус залруулагдсан алдаа байхгүй болно.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч аудитын хугацаанаас шалтгаалж эхний 9 сарын завсарын аудитад тулгуурлан цалингийн зардал, хөрөнгийн тооллогын бүртгэл тооцоо бодолтыг тулган шалгаж амжаагүй асуудлыг дараагийн аудитаар шалгах аар тогтоов.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Төв аймгийн Эрдэнэ сумын ЗДТГ-ын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар материаллаг хэмжээний 117775.4 мянган төгрөгийн, материаллаг бус 5749.4 мянган төгрөгийн буюу нийт 123524.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна.Үүнд:

1. Материаллаг хэмжээний нийт 117775.4 мянган төгрөгийн алдаа илэрснээс 3279.9 мянган төгрөгийг төсөвт төлүүлэх төлбөрийн акт бичиж, 114495.5 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулсан.
2. Материаллаг бус 5749.4 мянган төгрөгийн алдааг таслан загсоох давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төв аймгийн Эрдэнэ сумын ЗДТГазрын төсвийн 2015 оны санхүүгийн тайланд өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2016.07.01-ний өдрийн 06/74 тоотор ирүүлсэн байна. Хөрөнгийн асуудлыг бүрэн шийдвэрлээгүй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Төв аймгийн Эрдэнэ сумын ЗДТГазрын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 8 хуудас, байгууллагын санал .. хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ЖАРГАЛСАЙХАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

О.АМАРЖАРГАЛ

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

Т.МАЙЦЭЦЭГ